

Ээлжит хичээлийн нэр: Богино, үлгэр, өгүүллэг
ЗОХИОХ

Ээлжит хичээлийн зорилго: Үйл явдлыг цагийн дарааллаар өрнүүлэн, үйл явдлыг учир шалтгааны уялдаатай бичих

- Хэрэглэгдэхүүн:
- PPT\ ажлын хуудас
- Сурах бичиг

Зохион бичихдээ дараах зөвлөгөөг дагаарай.

1. Бичихийн өмнө асуулт бүхий бичих төлөвлөгөөг сайн унш.
2. Дараа нь ноороглож бич.
3. Ноороглосноо дахин унш.
4. Уншаад, зөв бичих дүрмийн алдаатай болон утга ойлгомжгүй өгүүлбэрийг засах
5. Алдаагүй гэж үзсэн үедээ дэвтэртээ хичээнгүй хуулан бичих

Өгсөн түлхүүр үгийг ашиглан, үйл явдлыг цагийн дарааллаар, учир шалтгааны уялдаатай өрнүүлж, богино үлгэр зохиогоорой.

1. Өгсөн түлхүүр үгсийг оролцуулах
2. Өгсөн бичих загварын асуултад хариулах замаар ажиллах

Сэдэв: Богино, үлгэр, өгүүллэг зохион бичих



Ашиглах түлхүүр үгс

Буга

- Цөөрөм, сүрлэг эвэр, бахархал, нарийн хөл, гомдол
- Арслан
- Айдас, хурд
- Мод, мөчир, эвэр, сандрал тэвдэл
- Амь мэнд, хөл, баяр хөөр

Эхлэл: (Эхлээд хэзээ, хаана юу болов?) -----

Зангилаа: (Тэгтэл ямар асуудал үүсэв?) -----

Өрнөл: (Тэгээд үйл явдал цааш яаж үргэлжлэв?) -----

Туйл: (Тэгж байтал дахин ямар асуудал хаана үүсэв?) -----

Тайлал: (Үүссэн асуудлууд яаж шийдэгдэв?) -----

Эхийн гол хэсэг

Төгсгөл: (Эцэст нь ямар сургамж болов?) -----

Ашиглах түлхүүр үгс

Буга

- Цөөрөм, сүрлэг эвэр, бахархал, нарийн хөл, гомдол
- Арслан
- Айдас, хурд
- Мод, мөчир, эвэр, сандрал тэвдэл
- Амь мэнд, хөл, баяр хөөр

Дараах шалгуурын дагуу өөрийгөө үнэлээд, түвшингээ тодорхойлоорой.

Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур	ГҮЙЦЭТГЭЛИЙН ХҮРЭХ ТҮВШИН			
	I-II	III-IV	V-VI	VII-VIII
Эхлэл, гол төгсгөл хэсгийн ялгаж бичдэг.	Эхлэл, гол, төгсгөлийг зааглаж ялгалгүй бичсэн.	Эхлэл, гол, төгсгөлийн аль нэгийг догол мөрөөр ялгалгүй бичсэн.	Эхлэл, гол, төгсгөлийг догол мөрөөр ялгасан боловч буруу ялгасан.	Эхлэл, гол, төгсгөл хэсгийг догол мөрөөр зөв ялгаж бичсэн.
Орон, цаг хугацааны дарааллаар уялдаа холбоотой бичдэг.	Эхийн агуулга бүхэлдээ уялдаа холбоогүй.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн боловч ихэнх хэсгийн уялдаа холбоо сул.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар бичсэн, зарим хэсгийн уялдаа холбоо сулб.	Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар өрнүүлэн учир шалтгааны уялдаа холбоо сайтай.
Эхийг ойлгомжтой, утга санааг тодорхой бичдэг.	Санаа нь тодорхойгүй, ойлгомж муутай.	Санаа нь тодорхой ч уншихад сонирхолгүй, жишээ баримт бараг ашиглаагүй.	Санаа нь тодорхой, ойлгомжтой, ашигласан зарим жишээ баримт тохироогүй.	Санаа нь тодорхой, ойлгомжтой, уншихад сонирхолтой, тохирсон жишээ баримт ашигласан.
Найруулга, ЗБД-ийн алдаагүй бичдэг.	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа ихтэй 6-аас дээш.	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 4-өөс дээш.	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн алдаа 3 ихтэй.	Найруулгын болон ЗБД, цэг тэмдгийн нэг ч алдаагүй.